



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗАР**



# **Хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн**

## **МЭДЭЭЛЭЛ**



**2023 оны 10 дугаар сарын байдлаар**

**Мөрөн сум**

## ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

### ТӨРӨЛТ

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 10 сарын байдлаар 1856 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 52 тохиолдол буюу 2.8 хувиар буурсан байна. Төрөлт Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Рэнчинлхүмбэ, Тосонцэнгэл, Улаан-Уул, Ханх, Цагаан-Уул, Цагааннуур сумдад өсч, Төмөрбулаг, Шинэ-Идэр сумдад адил, бусад сумдад өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Нийт төрсөн эхчүүдээс 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан хамрагдалтын хувь 72.5 хувь байна.




### ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 10 сарын байдлаар нийт 1865 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 51 тохиолдлоор буурсан байна. Амьд төрсөн хүүхдийн 2.9 хувь /55/ нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төрсөн. Төрөөд нэг цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 97.2 хувь байна. 5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтанд 2023 оны эхний 10 сард нийт 48749 хүүхэд жинлэж, жинлэсэн хүүхдийн 0.1 хувь нь туранхай, 0.1 хувь нь тураалтай, 0.1 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна. 23.8 хувь нь А амин дэм, 58.3 хувь нь Д амин дэм, 4.8 хувь нь олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн байна.

## НЯЛХСЫН ЭНДЭГДЭЛ


Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 10 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 16 тохиолдол бүртгэгдсэн нь 2022 оны мөн үеэс 14 тохиолдлоор буурч, 1000 амьд төрөлтөнд 9.5 ногдож байна. Нялхсын эндэгдлийн 43.8 хувийг нярайн эндэгдэл эзэлж, 1000 амьд төрөлтөд 8.6 байна. Нийт 11 тохиолдол буюу 68.8 хувь нь эмнэлэгт эндсэн бөгөөд 8 нь эрэгтэй хүүхэд байна.

Нялхсын эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл:



## 1-5 НАС ХҮРТЭЛХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ


2023 оны эхний 10 сарын байдлаар 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 11 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 7 тохиолдлоор өсч 1000 амьд төрөлтөнд 5.9 байна. Хүүхдийн эндэгдлийг оношоор нь авч үзвэл мэдрэлийн тогтолцооны эмгэг 1, хавдар 2, амьсгалын тогтолцооны эмгэг 2, төрөлхийн гаж хөгжил 2, осол гэмтлийн шалтгаант нас баралтын 4 тохиолдол бүртгэгдсэн байна.



## НАС БАРАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны эхний 10 сарын байдлаар 603 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 48 тохиолдлоор буурсан. Нийт нас баралтын 18.6 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс 38.4 хувь нь хоног болоогүй нас баралт байна. Осол гэмтлийн нас баралтын 70 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 40 тохиолдлоор буурсан, нийт нас баралтын 11.6 хувийг эзэлж, 10000 хүн амд 5.1 ногдож байна. Хорт хавдрын нас баралтын 179 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 12 тохиолдлоор өссөн, нийт нас баралтын 29.7 хувийг эзэлж, 10000 хүн амд 13.0 ногдож байна.


## Нас баралтын мэдээлэл, 2023 оны эхний 10 сарын байдлаар



Нийт нас баралтын тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 19.3
2. Хавдар- 13.0
3. Гадны шалтгаант өвчлөл- 5.1
4. Амьсгалын тогтолцооны өвчин- 1.6
5. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг- 1.6

## Осол гэмтлийн шалтгаант нас баралт, 2023 оны эхний 10 сарын байдлаар




Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 10 сарын байдлаар нийт эдийн шинжилгээ 1061, эсийн шинжилгээ 4872 хийгдсэн байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 72 нас баралтын 45.8 хувь нь эмгэг судлалын задлан шинжилгээ хийгдэж үндсэн оношийн зөрүү бүртгэгдээгүй. Задлан шинжилгээ хийгдээгүй нас баралт 39 тохиолдол байна.

## АМБУЛАТОРИ СТАЦИОНАРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ


Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 10 сарын байдлаар амбулаторид нийт 469742 үзлэг хийгдсэнээс 36.8 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 51.4 хувийг өвчний учир амбулаторид, 4.6 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 5.2 хувийг гэрийн идэвхитэй үзлэг, 2.0 хувийг гэрийн дуудлагын үзлэг эзэлж байна.

### Амбулаторийн үзлэгийн төрөл

■ 2022 ■ 2023




### Амбулаторийн үзлэг, 2022-2023 оны эхний 10 сарын байдлаар



### ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТ

Шинээр хяналтанд авсан нийт 1671 жирэмсэн эмэгтэйчүүдээс 92.6 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтанд орж цусны шинжилгээнд 95.9 хувь нь хамрагдан, үүнээс 1.6 хувь нь цус багатай гарсан байна. Эхний 10 сарын байдлаар жирэмсний хяналтанд шинээр орсон эхчүүдээс трихомониаз, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 91.8 хувийг, тэмбүү болон ХДХВ илрүүлэх шинжилгээнд 94.9 хувийг тус тус хамруулж заг хүйтэн-26 трихомониаз-8, тэмбүү-13 тохиолдлыг бүртгэн эмчилсэн байна.

Жирэмсэний эрт хяналтын хувь,  
2023 оны эхний 10 сарын байдлаар



### ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

2023 оны эхний 10 сарын байдлаар халдварт бус өвчлөл 120402 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 20261 тохиолдлоор өссөн байна. 10000 хүн амд 8735.5 байгаа ба осол гэмтлийн өвчлөл 1301 бүртгэгдэж, нийт халдварт бус өвчний 1.1 хувийг эзэлж, 10000 хүн амд 94.4 байна.

Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 1898.6
2. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин- 1811.0
3. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин- 1580.5
4. Шээс бэлгэсийн тогтолцооны эмгэг- 922.4
5. Мэдрэлийн тогтолцооны өвчин- 718.6


Стационарт нийт 24698 хүн хэвтэн эмчлүүлж, 165091 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 6.7, орны эргэлт 24.7, орны фонд ашиглалт 164.9, фонд ашиглалтын хувь 60.0 байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 10 сарын байдлаар нийт 15129 түргэн тусламжийн дуудлага хүлээж авч гүйцэтгэснээс 17.0 хувь /2571/ нь алсын дуудлага, 3.9 хувь /590/ нь осол гэмтлийн дуудлага байна. Аймгийн хэмжээнд 1 өдөрт дунджаар 50.4 дуудлага, Нэгдсэн эмнэлэг 16.1 дуудлага тус тус хүлээн авч гүйцэтгэжээ.


### ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны эхний 10 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 44374 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 50.6 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 42.3 хувь нь эрэгтэй, 57.7 хувь нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 5534 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон артерийн гипертензи 475 буюу 8.6 хувь нь онош баталгаажсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 33489 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 63.3 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 41.6 хувь нь эрэгтэй, 58.4 хувь нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 1861 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон 32 буюу 1.7 хувь нь онош баталгаажсан байна.


### Эрт илрүүлэг үзлэгийн хувь, нэгжээр



### Эрт илрүүлэг үзлэгийн хувь, нэгжээр



### Эрт илрүүлэг үзлэгийн хувь, нэгжээр





## **ӨРХИЙН ЭМТ-ИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

Өрхийн ЭМТ нийт үзлэг 95120 байгаа ба үзлэгийн төрлөөр нь авч үзвэл:

- Урьдчилан сэргийлэх үзлэг 53.6 хувь
- Өвчний учир үзлэг 24.6 хувь
- Диспансерийн хяналт 7.2 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 13.9 хувь
- Гэрийн дуудлага 0.7 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт бус өвчний 12756 тохиолдол бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 5.8 хувийг, 5 хүртэлх насны хүүхдийн халдварт бус суулгалт 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Шинээр хяналтанд авсан 595 жирэмсэн эмэгтэйгээс 91.8 хувийг эрт үед нь хяналтанд авч 100 хувь цусны шинжилгээнд хамруулсан байна.

Нийт 193 нас баралт бүртгэгдсэн ба аймгийн Нэгдсэн эмнэлэгт 35 тохиолдол байна. Хорт хавдрын нас баралт 68, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 8 тохиолдол бүртгэгдсэнээс аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2 тохиолдол бүртгэгдсэн байна.

## **ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

Хувийн эмнэлгүүд нийт 28104 үзлэг хийснээс

- Урьдчилан сэргийлэх үзлэг 14.1 хувь
- Диспансерийн хяналт 2.6 хувь
- Өвчний учир үзлэг 83.3 хувийг тус тус эзэлж байна.

Стационариар нийт 6642 хүн хэвтэн эмчлэгдэж, 48211 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.3 орны эргэлт 21.9 ба орны фонд ашиглалт 159.1, орны фонд ашиглалтын хувь 57.9 байна. Нийт халдварт бус өвчний 37 тохиолдлоос 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 26 тохиолдол бүртгэгдсэн байна.

## **ХАЛДВАРТ ӨВЧИН**

Аймгийн хэмжээнд эхний 10 сарын байдлаар 1031 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 74.8 ногдож байна. 2022 оны мөн үед 5386 тохиолдол, 10000 хүн амд 393.6 ногдож байжээ.

10000 хүн амд ногдох халдварт өвчний гаралт Тариалан, Тосонцэнгэл, Цэцэрлэг, Мөрөн сумдад аймгийн дунджаас их байна. Нийт халдварт өвчнөөс бэлгийн замаар дамжих халдвар 60.7 хувь, сүрьеэ 5.9 хувь, амьсгалын замын өвчин 15.5 хувь, цусан халдвар 0.7 хувь, гэдэсний халдварт өвчин 11.0, арьс салстаар халдварлах халдвар 0.8, зоонозын болон мал амьтнаас хүнд халдварладаг өвчлөл 0.9 хувь, Ковид-19 халдвар 4.5 хувийг тус тус эзэлж байна.

## **ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН**

Нийт цочмог халдварт өвчний 1031 тохиолдлоос:


- Сальмонеллэз 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Халдварын гаралтай гастроэнтерит ба суулга 2 тохиолдол буюу 3 тохиолдлоор
- Хепатит А 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хепатит С 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хачигт рикеттиоз 7 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор

- Ковид-19 46 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 4230 тохиолдлоор тус тус буурч
- Цусан суулга 55 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 31 тохиолдлоор
- Хоолны хордлого 56 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 48 тохиолдлоор
- Хачигт энцефалит 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хепатит В 5 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Ёлом 10 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 7 тохиолдлоор
- Салхинцэцэг 132 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 83 тохиолдлоор
- Гар хөл амны өвчин 22 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 19 тохиолдлоор
- Улаан-Эсэргэнэ 5 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор тус тус өсч
- Сүрьеэ 61 тохиолдол буюу өмнөх оны мөн үетэй адил
- Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс халдварт саа, сахуу, хөхүүл ханиад, татран, менингококкт халдварын өвчлөл бүртгэгдээгүй байна.




## ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ


1. 2023 оны эхний 10 сарын байдлаар халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц 328 тохиолдол мэдээлэгджээ. Үүнээс халууралт тууралт 19.5 хувь /65/, цэврүүт тууралт 45.5 хувь /149/, цочмог цусархаг суулгалт 14.0 хувь /46/, шарлалттай 2.1 хувь /7/, цочмог усархаг 1.8 хувь /6/, хоолны хордлогот халдвар 17.1 хувь /56/ тус тус бүртгэгдсэн байна.
2. Нийт мэдээлэгдсэн хам шинжийн өвчлөл /бодит тоогоор/



### Халдварт өвчний хамшинж, сэжигтэй нийт тохиолдол, бүртгэгдсэн долоо хоногоор




### Халдварт өвчний хамшинж сэжигтэй өвөрмөц тохиолдол бүтцээр, 43-р долоо хоногийн байдлаар




## ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН

2023 оны эхний 10 сарын байдлаар аймгийн хэмжээнд ТТӨ-ий 22681 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 1646.0 болсон байна. Харин өнгөрсөн оны мөн үед 22662 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 1656.1 байсан байна.


### Томуу, томуу төст өвчин, 10 000 хүн амд



Томуу, томуу төст өвчин (насны бүлэг, хувиар)



АЗЦХХ-ын хэвтэлт (насны бүлэг, хувиар), 2023 он




## БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН


Нийт халдварт өвчний дотор бэлгийн замын халдварт өвчний эзлэх хувь 60.7 хувь /626/ байгаа ба өнгөрсөн оны мөн үед 17.3 хувь /933/ байсан байна. Бүртгэгдсэн тохиолдлоос

- Гонококкт халдвар 477 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 260 тохиолдлоор
- Трихомониаз 42 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 17 тохиолдлоор
- Тэмбүү 107 тохиолдол буюу 30 тохиолдлоор тус тус буурсан байна.


Бэлгийн замын халдварт өвчин, 2023 оны эхний 10 сарын байдлаар



БЗХӨ, насны бүлгээр, 2023 оны эхний 10 сарын байдлаар



БЗХӨ, боловсролын түвшингээр, 2023 оны эхний 10 сарын байдлаар



ХЯНАСАН:

ДҮГНЭЛТ ХИЙСЭН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.МӨНХ-АЮУШ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН  
АЖИЛТАН П.НЯМЖАВ